



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 04 өдөр

Дугаар А/461

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Монгол Улсын Их хурлын 2022 оны 36 дугаар тогтоол, Засгийн газрын 2022 оны 424 дүгээр тогтоол, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2023 оны А/59 дүгээр тушаал, 2023 оны “Төсөвт зохицуулалт хийх тухай” А/399 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлан хэрэгжүүлж буй “Хүнсний хувьсгал” үндэсний хөдөлгөөн, Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын 2023 оны А/59 дугаар тушаалын хэрэгжилтийг хангах хүрээнд “Органик Хөвсгөл-Органик мах” арга хэмжээг зохион байгуулах үйл ажиллагааны зардалд 29,000,000 (Хорин есөн сая) төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх зардлын 29,000,000 (Хорин есөн сая) төгрөгийг “Засаг даргын мөрийн хөтөлбөр хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардал”-аас гаргаж, Хүнс, хөдөө аж ахуйн газрын нэмэлт дансанд шилжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Батбилгүүн)-т зөвшөөрсүгэй.

3. Арга хэмжээг батлагдсан төсвийн хүрээнд, удирдамжийн дагуу үр дүнтэй зохион байгуулж, тайлагнахыг ажлын хэсгийн ахлагч (М.Хуягбаатар), аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар (Я.Эрхэмбаяр) нарт тус тус үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газар (Б.Батбилгүүн)-т үүрэг болгосугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ